

Премьер лиг

Дэлхийн хамгийн олон

үзэгчтэй спорт бол яахын аргагүй хөлбөмбөг билээ. Дэлхий дээр нэг тэрбум хүн хөлбөмбөгийг шимтэн үздэг бол тэдний бараг тал нь энэ спортод амь амьдралынхаа нэг хэсэг болгосон донтой үзэгчид байдаг. Тэгвэл хөлбөмбөгт хэд хэдэн томоохон

тэмцээн болдог ба хамгийн алдартай нь Дэлхийн аварга болон Аваргуудын лиг билээ.

Дэлхийн аваргашалгаруулах тэмцээн улсуудын хооронд явагддаг бол Аваргуудын лиг

нь Европт өөрөөрийн улсдаа аварга авсан шилдэг багууд ордог клубуудын дундах

тэмцээн. Барагулс бүр өөр өөрийн гэсэн лигтээ байдаг. Улс бүрийн дотоодын лиг бараг

ижилдүрэмтэй. Баг бүр бусад бүх багтай 2 удаа тоглоно. Нэг тоглолт нь өөрийн талбай

дээрх нөгөө тоглолт нь айлын талбай дээр явагддаг. Баг бүр ядаж 2 өөр өнгийн

өмсгөлтэй байдаг. Гэрийн болон айлын гэж ч нэрлэж болно. Өөрийн талбай дээр

тоглохдоо заавал гэрийн өмсгөлөө өмсөх ёстой бол айлын талбай дээр айлын

өмсгөлөө өмсөнө. Ямар нэг тоглолтонд эзэн багийн гэрийн өмсгөл зочин багийн

айлын өмсгөл 2 адил өнгөтэй бол зочин баг нь гэрийн өмсгөлөө өмсдөг байна.

Клубууд өөрийн багийн өмсгөлийг зарж маш их хэмжээний мөнгө олдог. Клуб бүр

өөрийн өмсгөлийг хийх спорт хувцасны компанитай гэрээ байгуулдаг. Уг компанийн

ард зөвхөн өмсгөл худалдаалах хэсэг хариуцсан бүхэл бүтэн хэлтэс ажилладаг

байна. Энэ хэлтсийн хийдэг ажлыг энгийнээр хэлэхэд аль клубын аль өмсгөл хэр их

зарагдах магадлалтайг тооцоолдог байна. Энэ тооцоог хийхэд наад зах нь баг

бүрийн гэрийн болон айлын өмсгөлтэй

хэдэн тоглолт хийх ёстойг мэдэж байх шаардлагтай.

Танд аль нэг улсын

лигийн багуудын өмсгөлүүдийн өнгөний мэдээлэл өгсөн бол баг бүрийн гэрийн

өмсгөлтэй тоглох тоглолт болон айлын өмсгөлтэй тоглох тоглолтын тоог олж чадах

уу?

Оролт

Эхний мөрөнд нийт багийн тоо болох $N < 100000$ тоо.

Дараагийн N ширхэг мөр бүр нэг нэг багийг илтгэнэ. i дүгээр багийн гэрийн болон

айлын өмсгөлийн өнгийгилэрхийлэх тоо зайгаар тусгаарлаглан өгөгдөнө. Өнгийг

тоогоор илэрхийлэхдээ ижил өнгөтэй бол ижил тоо, ялгаатай өнгөтэй бол ялгаатай

тоо байхаар шифрлэнөгсөн байгаа.

Гаралт

Гаралт N мөрөөс тогтоно. i дүгээр мөр 2 тоо байна. Эхний тоо нь i дүгээр багийн

гэрийн өмсгөлтэй хийх тоглолтын тоо, 2 дахь тоо нь айлын өмсгөлтэй хийх

ТОГЛОЛТЫН ТОО.

Жишээ оролт

Input	Output
3	2 2
1 2	2 2
3 4	3 1
5 1	